

PRODUCTION



ҮЙЛДВЭРЛЭЛ УРЛАЛЫН
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

Сайна ТУРШЛАГА

СУРГАЛТЫН АЛБА

2024



САЙН ТУРШЛАГА ГЭЖ ЮУ ВЭ?

Сайн туршлагыг сонгож баримтжуулах ажлыг сургалтын албаны үйл ажиллагааны төлөвлөгөөнд оруулан, олон улсын болон үндэсний хэмжээнд өөрийн ажил үүргийн хүрээнд хүлээн зөвшөөрөгдөхүйц үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэхэд чиглэгдсэн, судалгааны ажил гэж үзэж байна.

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагуудын сургалтын үйл ажиллагаанд аль нэг түвшинд хэрэгжин үр дүнгээ өгсөн үйл ажиллагааг бүхэлд нь буюу зарим нэгэн хэсгийг нь сайн туршлага гэж тодорхойлж болно. тухайн үйл ажиллагааны цар хүрээнээс хамаарахгүйгээр уг ажил амьдралд туршигдан үр дүнтэй болсон байх нь сайн туршлага хэмээн үзэх гол шалгуур болдог. Амьдралд туршигдаж үзсэн байдгаараа сайн туршлага нь шинэ санаачлагаас ялгаатай. Үйл ажиллагааны талаарх жирийн нэг жишиг болсон баримтууд бус харин тухайн ажил ямар үр дүнд хүрснийг нотлох нотолгоо нь сайн туршлагыг баримтжуулахад заавал хэрэглэгдэх ёстой зайлшгүй хэрэгцээтэй мэдээлэл болдог.

Сайн туршлага нь дараах 7 шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдоно.

Шинийг санаачилсэн, бүтээлч байдал

Үр дүн ба үр нөлөө үзүүлсэн байдал

Тогтвортой байдал

Практик ажиллагаанд нийцсэн байдал

Үр ашиг ба хэрэгжилт

Сайн туршлагыг 3 түвшинд ангилж болно /Сайн туршлагыг тодорхойлох, бүтцийг хянах, түгээх, нэвтрүүлэх нь баримт бичиг 2001.10/

Түвшин 1: Шинийг санаачлах туршлага

7 шалгуур үзүүлэлтийн дагуу амжилттай туршигдсан үйл ажиллагаа

Түвшин 2: Амжилттай туршин хэрэгжүүлсэн туршлага

Тодорхой нэг орчинд амжилттай туршигдан, үр дүнг баталгаажуулсан

Өөр орчин, нөхцөлд ашиглах боломжтой практик үйл ажиллагаа

Түвшин 3: Түгээгдсэн сайн туршлага

Янз бүрийн орчин, нөхцөлтэй олон газарт туршигдан төсөөлсөн үр дүнд хүрч чадсан практик үйл ажиллагаа.

Сайн туршлагыг сонгож тодорхойлохдоо сургуулийн болон холбогдох байгууллагуудаас хийсэн ажиглалт, санал, судалгаа, ярилцагын үеэр цуглуулсан материал, баримт өөрөөр хэлбэл материалуудын бодит байдлаас тодруулсан болно.

Сайн туршлагын эхлэлийг сургуулийн Зөвлөх багш нарын хүрээнд хийсэн бөгөөд 2024-2025 оны хичээлийн жилд Тэргүүлэх багш нарынхаар хийхээр төлөвлөж байна.

СУРГАЛТЫН АЛБА

САЙН ТУРШЛАГА №1

БИЙЧААГИЙН МЯДАГБАДАМ




Боловсролын салбарт 24 жил, үүнээс мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад 16 жил тасралтгүй ажиллаж байна. Одоо үйлдвэрлэл урлалын политехник коллежийн сургалтын менежерийн ажлыг эрхэлдэг.

- Боловсролын зэрэг: Боловсролын удирдлагын магистр
- Мэргэжлийн зэрэг: ЗӨВЛӨХ БАГШ
- “Насанд хүрэгчдийн заах арга зүй”, “Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр, үнэлгээ”, “ЧСС-ын багшийн заах арга зүйн үндэсний сургагч багш” “Гэрчилгээ-IV”, “Диплома” олон улсын баталгаажсан багшлах эрхтэй.

САЙН ТУРШЛАГА 1: МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ЧАНАРЫН БАТАЛГААЖИЛТЫГ ХАНГАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН.

1. 4 хөтөлбөр БМИҮЗөвлөлөөр магадлан итгэмжлүүлсэн.
2. Байгууллагын магадлан итгэмжлэлд баг хамт олноороо магадлуулсан.
3. Сургалтын байгууллагын ISO21001 стандарт хангахаар ажиллаж байна.



ҮР ДҮН: Дээрх чанарын баталгаажилтийг хангах ажлыг зөв төлөвлөн, багийн зохион байгуулалтыг оновчтой хийсэн. Бид төлөвлөлт-хэрэгжүүлэлт-хяналт-сайжруулалт бүхий чанарын менежментийг хэрэгжүүлж ажиллаж байна. PDCA аргын дагуу чанарын сайжруулалт хийхдээ сайн төлөвлөгөө (P) болон үйл ажиллагаанаас эхэлбэл илүү үр дүнтэй байдаг.

Төлөвлөгөөг хэрэгжүүлэх (гүйцэтгэл D), үр дүнг шалгах (C), үр дүнгийн шалтгааныг ойлгох, үйл явцыг сайжруулахын тулд (A) арга хэмжээ авах гэсэн тойрог хэлбэрээр үргэлжлүүлсээр илүү өндөр стандарт, илүү чанартай ажлын гүйцэтгэлийг бий болгодог.

САЙН ТУРШЛАГА 2: СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХӨТӨЛБӨРТ АЖЛААР ЗОХИОН БАЙГУУЛЖ, БАГААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧМЫГ БАРИМТЛАН АЖИЛЛАДАГ. ҮҮНД:

“Багш хөгжлийн хөтөлбөр”, “Суралцагч -Оролцоо-Ирээдүй” хөгжлийн хөтөлбөр, “Дотуур байр миний гэр” хөтөлбөр, “Үлдээх хөтөлбөр”, “Эрүүл оюутан” хөтөлбөрүүдийг урт богино хугацааны зохион байгуулалттайгаар хэрэгжүүлж байна.

САЙН ТУРШЛАГА 3: НЭЭЛТТЭЙ СУРГУУЛЬ, СУДАЛГАА ИННОВАЦ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА.

Нэгдсэн хөтөлбөр боловсруулах явцад оролцогч талуудыг тодорхойлох, хөтөлбөрөөс хүлээх хүлээлт, сонирхлыг судалж үнэлэх, хэрэгжүүлэх явцад оролцогчдын оролцоо, үүрэг хариуцлага зэрэгт дүн шинжилгээ хийж ажиллах нь ажлын уялдаа холбоог сайжруулж байна.

ҮР ДҮН:

Сургуулийн эрхэм зорилго, алсын харааг хэрэгжүүлэхэд томоохон үүрэг бүхий нээлттэй сургууль болох зорилтыг хэрэгжүүлэхэд дараах үйл ажиллагааг чиглүүлж ажиллалаа.

- Сургалтын албаны нийт үйл ажиллагаанаас 17 чиглэлийн ажлыг багш нараар хянуулж, дотоод чанарын баталгаажилт ханган ажилладаг.
- Багшийн өөрийн үнэлгээний системийг дараах байдлаар хийж хэвшүүлж байна.



САЙН ТУРШЛАГА №2

ИЧИНХОРЛООГИЙН ОЮУНЧИМЭГ



Боловсролын салбарт 27 жил, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагад 23 жил ажиллаж байна. Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн сургалтын арга зүйчээр ажилладаг.

- Боловсролын зэрэг: Хэл шинжлэлийн магистр
- Мэргэжлийн зэрэг: ЗӨВЛӨХ БАГШ
- Мэргэжлийн боловсрол сургалтын насанд хүрэгчдийн заах арга зүй, ажлын байран дээрх сургалтыг зохион байгуулах үндэсний сургагч багш
- Мэргэжлийн боловсрол, сургалтын чадамжийн үнэлгээний мэргэшсэн үнэлгээний ажилтан, баталгаажуулагч

- ХНХЯ, БХЯ, БСШУЯ, СЯамны хамтран хэрэгжүүлсэн 5000 ажилтан бэлтгэх “ОРОЛЦОО” төслийн үндэсний сургагч багш

САЙН ТУРШЛАГА 1: БАГШ НАРЫГ СУРГАЛТЫН АРГА ЗҮЙД СУРГАХ, БАГШЛАХ УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ, СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН БЭЛТГЭХ, ЭЭЛЖИТ ХИЧЭЭЛ ТӨЛӨВЛӨХӨД ЗӨВЛӨН ТУСАЛЖ, ЧИГЛҮҮЛЖ АЖИЛЛАСАН.

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДЫН БАГШ НАРЫН
"ШИЛДЭГ АРГА ЗҮЙЧ" ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНД ҮЗҮҮЛСЭН АМЖИЛТ

[illegible]

ҮР ДҮН: Сүүлийн 10 гаруй жил бэлтгэсэн багш нар тогтмол улс, бүсийн уралдаанд эхний байрвудыг эзэлж байна.

САЙН ТУРШЛАГА 2: СУРГАЛТЫН ЧАНАР, БАГШИЙН УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ
ЗОРИЛГООР ЭЭЛЖИТ ХИЧЭЭЛИЙН ЯВЦАД ҮНЭЛГЭЭ ХИЙХ, ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ШАЛГУУР
ҮЗҮҮЛЭЛТИЙГ ЧАДАМЖИД СУУРИЛСАН СУРГАЛТАД ТУЛГУУРЛАН БОЛОВСРУУЛЖ
ХЭРЭГЖҮҮЛСЭН.

ҮР ДҮН:

- Багшлах ур чадвар, ээлжит хичээлд бэлтгэх төлөвлөх арга барил сайжирч бүс, улсад туршлагаа түгээсэн багш нар нэмэгдсэн.
- Шинэ залуу багш нарт “Ээлжит хичээлд бэлтгэх” сургалт явуулж хэвшсэн.

[illegible][illegible]

САЙН ТУРШЛАГА №3

ДАВААДОРЖИЙН НАРАНТУЯА



Боловсролын салбарт 25 жил, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагад 17 жил ажиллаж байна. Одоо үйлдвэрлэл урлалын политехник коллежийн Багшийн хөгжил, инноваци хариуцсан арга зүйчээр ажилладаг.

- Боловсролын зэрэг: Боловсролын удирдлагын магистр
- Мэргэжлийн зэрэг: ЗӨВЛӨХ БАГШ

САЙН ТУРШЛАГА:

1. Улсын чанартай уралдаан тэмцээнээс амжилт гаргасан багш, суралцагчдыг алдаршуулах булан ажиллуулсан.

ҮР ДҮН: 2023 оны хичээлд нийт 23 багш, суралцагч улсын чанартай уралдаан, тэмцээн амжилттай оролцсоныг сургуулийн Нээлттэй хаалганы өдөрлөгөөр түгээн дэлгэрүүлэн булан ажиллуулсан.

2. Багш ажлын байран дээр хөгжих сургалтууд зохион байгуулсан.

ҮР ДҮН: Багшийн ажлын байран дээр хөгжих сургалтуудыг багшийн өөрийн хөгжлийн төлөвлөгөөн дээр тулгуурлан хэрэгцээний сургалтын судалгаанаас төлөвлөгөө гарган зохион байгуулсан. 15 сургалт зохион байгуулагдаж 1200 багш /давхардсан тоогоор/ хамрагдсан байна.

3. “Зурган гарын авлага” боловсруулалт түгээн дэлгэрүүлэх ажил хийсэн.

ҮР ДҮН: Зурган гарын авлага боловсруулах уралдааныг зохион байгуулж нийт 36 багш оролцсоноос 4 багшийн бүтээлийг түгээн дэлгэрүүлсэн байна.

4. Хөтөлбөрийн баг, багшийн бичиг баримт хөтлөлт, анги удирдах тэргүүн туршлага түгээн дэлгэрүүлэлт

ҮР ДҮН: Хөтөлбөрийн багийн ахлагч нарын бичиг баримтын боловсруулалтанд зөвлөн туслах хийж Үсчин мэргэжлийн хөтөлбөрийн багийн бичиг баримт бүрдүүлэлтийг түгээн дэлгэрүүлсэн. Багш нарын хичээлийн хэрэглэгдэхүүнд зөвлөн туслах хийж ЗБЖБҮА-ы мэргэжлийн багш З.Долгормаагийн хичээл хэрэглэгдэхүүнээр түгээн дэлгэрүүлэлт хийсэн. Анги удирдсан багшийн хөтлөх мэдээллийн сан бүрдүүлэлтээр оёдлын багш Г.Жаргалсайхан багшаар тэргүүн туршлага түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулсан.

5. Онол практикийн бага хурал зохион байгуулсан.

ҮР ДҮН: Бидний оролцоо- Бидний ирээдүй сэдвийн хүрээнд суралцагчдын дунд Багшийн заах арга зүйд нэвтрүүлж буй арга техник, сургалтын орчин бүрдүүлэлт, сургалтын хэрэглэгдэхүүнд гарч буй өөрчлөлт, шинэчлэлт

“Чанартай сургалт-чадварлаг төгсөгч” – дадлагажигч, дадлагажуулагч, мэргэжлийн багш нарын дунд зэрэг онол практикийн бага хурлыг зохион байгуулсан.

6. Багш нарын бүтээлийн санг нэмэгдүүлэх, СААЗ-өөр хэлэлцүүлэх

ҮР ДҮН: Нийт 25 багшийн гарын авлага, сурах бичгийг СААЗ-өөр хэлэлцүүлэн батлуулсан байна.

САЙН ТУРШЛАГА №4

СҮРЭНХҮҮГИЙН ЦЭНД-АЮУШ



Улсад 25 жил ажилласан. Үүнээс мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад 13 дах жилдээ багшилж байна. “ЗӨВЛӨХ БАГШ”, дэлхийн ур чадварын уралдааны “ЭКСПЕРТ БАГШ”.

БОЛОВСРОЛ:

- Худалдааны техникум- Нийтийн хоолны технологич
- МУИС, Эдийн засгийн сургууль- Бизнесийн удирдлага
- Технологийн дээд сургууль- Хүнс судлалын магистр

МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭСЭН БАЙДАЛ:

- Турк улсын төрийн үйлчилгээний Анкара ордонд 2006 онд 3 сар дадлагажих
- БНСУ-д 2011, 2019, 2023 онуудад 3 удаа хоол үйлдвэрлэлийн мэргэжлээр богино хугацаанд
- АНУ-ын Illinois мужийн Crystal lake хотын “Alexander leigh center forautizm” хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуульд 2008-2010 онуудад хоолны багшаар
- HEI компанийн сүлжээ “Chateauelan” цогцолборт 2017-2018 онуудад хоолны технологичоор
- БНХАУ-ын Вэнхай Мэргэжлийн сургуульд 2019 онд богино хугацаагаар мэргэжил дээшлүүлсэн.

САЙН ТУРШЛАГА 1: “ТОГООЧ” МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТАД ЗОРИУЛСАН ЧАДАМЖИЙН ГАРЫН АВЛАГА БОЛОВСРУУЛСАН.

Ажил олгогч эздийн холбоотой хамтран улсын хэмжээгээр мөрдөгдөж буй “Тогооч” мэргэжлийн сургалтад зориулсан 8 чадамжийн гарын авлага боловсруулж, насанд хүрэгчдийн болон мэргэжлийн боловсролын сургалтад ашиглаж байна.

САЙН ТУРШЛАГА 2: ТОГООЧ МЭРГЭЖЛИЙН 152 БАГШ НАРТ ЦАХИМ СУРГАЛТ, УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛСАН.

МБСҮМАЗТ-ийн сургалтын агуулга, стандарт, хөтөлбөр хариуцсан арга зүйчидтэй хамтран “Арга зүйн цаг” булангаар Тогооч мэргэжлийн 152 багш нартай цахим сургалт, уулзалтыг 2 удаагийн давтамжтай зохион байгууллаа. Тус сургалтанд:

- Чадамжийн стандарт
- Хөтөлбөр, сургалтын төлөвлөгөөний боловсруулалт, агуулга, багц цагийн өөрчлөлт
- Мэргэжлийн багшийн мэдлэг, ур чадварыг ахиулах
- Дотоодын болон гадаадын сургалтын хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгаанууд зэрэг мэдээ мэдээлэл өгч, асуултанд хариулж, салбарын хэмжээнд өөрийн туршлага түгээсэн.



САЙН ТУРШЛАГА 3: “ДЭЛХИЙН УР ЧАДВАР”-ЫН ТЭМЦЭЭНД ТОГООЧ МЭРГЭЖЛИЙН ЭКСПЭРТ БАГШААР 2 УДАА ОРОЛЦСОН.

“Монгол ур чадвар” тэмцээнд оролцогчдыг 2015 оноос хойш бэлтгэж, эксперт багшаар 2 удаа монгол улсаа төлөөлж “Дэлхийн ур чадвар”-ын тэмцээнд оролцож, амжилтаа ахиулсаар байна. Дэлхийн ур чадварын тогооч мэргэжлийн 41 улсын экспертүүдээс эхний 9-д багтан, олон улсын үнэлгээнд 5 улсын экспертүүдийн багийн ахлагчаар ажилласан.



САЙН ТУРШЛАГА №5

БАТЖАРГАЛЫН АНХБАЯР



Улсад 25 жил ажилласан. Үүнээс мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад 25 дах жилдээ багш, тэнхимийн эрхлэгчээр ажиллаж байна. “ЗӨВЛӨХ БАГШ”.

БОЛОВСРОЛ:

- ХААИС- Эдийн засагч
- ХААИС- Бизнесийн удирдлагын магистр

САЙН ТУРШЛАГА 1: МБС-ЫН БАЙГУУЛЛАГАД СУРАЛЦАГЧИЙН ӨРТГИЙН ТООЦОО ХИЙН ХИЧЭЭЛ ПРАКТИКИЙН ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ БОЛОМЖИЙГ ЭРЭЛХИЙЛСЭН.


Бизнесийн бүхий л байгууллага өөрийн үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний өртгийг тогтмол тооцож зардлаа төлөвлөдөг. Сургалтын байгууллагын хувьд их дээд сургуулиуд нэг суралцагчийн зардлын тооцоог судалж сургалтын төлбөрөө тогтоодог. МБС-ын байгууллагын хувьд төдийлөн судлагдаагүй, төдийлөн бодит тооцоолол хараахан гараагүй байх үед дараах асуудал бидэнд тулгарч байсан.

МБС-ын байгууллагад тулгамддаг асуудлууд дараах байдалтай байна. Үүнд:

- Суралцагчийн сургалтын мэргэшүүлэх зардлыг хэрхэн тогтоох вэ?
- Нэг суралцагчийн өөрийн өртгийн тооцоог мэргэжил бүрээр хэрхэн тооцох вэ?

2014 онд МБС-ын багш нарын илтгэлийн уралдаанд “ МБС-ын байгууллагад суралцагчийн өртгийн тооцоо хийх нь” сэдвээр илтгэл хэлэлцүүлж энэхүү асуудлыг хэрхэн шийдэх талаар хөндсөн. Мэргэжил бүрийн сургалтын тооцоог судлах чадамжийн агуулга, хэрэглэгдэхүүн, цагийн багтаамж зэргээс хамаарч нэг мэргэжлээр өөр өөр агуулга, хугацаатай төлөвлөхөд өөрийн өртөг нь ялгаатай гарч болохыг илтгэлдээ дурьдсан тооцоолж харуулсан. Түүнчлэн 2014-2018 онуудад УББАЗТөвийн багшлах эрх олгох сургалтад хамрагдсан багш нарт энэхүү агуулгаар сургалт явуулснаар сургалтын төвүүд өөрийн өртгийн тооцоолол дээр үндэслэн төлбөрийн хэмжээг тодорхойлж байсан.

ҮР ДҮН: 2020 оноос бодлогын хүрээнд МБСБ-ууд мэргэжил бүрээр өөрийн өртгийн тооцоог жишиг байдлаар хийсний үр дүнд МБСБ-ууд 2024 оноос санхүүжилтээ өөрийн өртөгт тулгуурлан хийхээр төлөвлөгдөж байна.



САЙН ТУРШЛАГА 2: МБСБ-Д СУРАЛЦАГЧИД БҮТЭЭЖ БҮЙ БҮТЭЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨӨРИЙН ӨРТГИЙГ ТООЦООЛЖ УЛМААР БОРЛУУЛАХ ҮНЭЭ ТОДОРХОЙЛОХ АРГА ЗҮЙД ЗААЖ СУРГАСАН.

МБС-ын 2-р курсын суралцагчид эзэмшиж буй мэргэжлийнхээ дагуу бүтээл хийх, үйлчилгээ үзүүлэх тохиолдол их гардаг. Бүтээл, үйлчилгээгээ борлуулах боломжийг суралцагч эрэлхийлэх үед үнээ зөвхөн материалын зардлыг нэмэгдүүлэх эсвэл бусдын импортын барааны үнээр харьцуулан тогтоож байгаа нь ашиг орлого баримжаатай байх хэрэгцээ шаардлага тулгарч байсан. Үүнийг шийдвэрлэхээр “Хувь хүний санхүү бизнес эрхлэх” чадамжийн хөтөлбөрт “Бүтээгдэхүүний өөрийн өртөг тооцох” агуулгыг 2016 оноос оруулж сургалт явуулсан.

Сургалтаар гүйцэтгэсэн бүтээл, үйлчилгээний өртөг тооцох аргаар суралцагчдыг дадлагажуулсан.

ҮР ДҮН: Бие даан бүтээл гарган борлуулах суралцагчдын тоо нэмэгдсэн. Суралцагчид бизнес хийх сэдэл тэмүүлэлтэй болсон. 2016-2018 онд “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-өөс 8 бүлэг санхүүжилт авч өөрийн бизнесийг эхлүүлэн өнөөг хүртэл тогтвортой ажиллаж байна.

САЙН ТУРШЛАГА №6

ДЭЛГЭРБАЯРЫН ОДГЭРЭЛ



Улсад 25 жил ажилласан. Үүнээс мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад 13 дах жилдээ багшилж байна. “ЗӨВЛӨХ БАГШ”, “МАСТЕР ҮСЧИН”


БОЛОВСРОЛ:

- Үйлдвэрлэл үйлчилгээний техникийн дунд сургууль- Үсчний урлал” мэргэжлээр техникийн боловсрол
- Үйлдвэрлэл урлалын сургууль- “Нүүр будаг, гоо заслын технологич” мэргэжлээр бакалавр
- СУИС-“Соёлын удирдлага, эдийн засаг” мэргэжлээр магистр

САЙН ТУРШЛАГА 1: МЭРГЭЖЛИЙН СТАНДАРТ, АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАХ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫГ ХЭСЭГТ АЖИЛЛАСАН.

- 2009 онд БСШУЯ-ны “Мэргэжил арга зүйн” төвтэй хамтран МБС-ын стандарт MNS 5370:2004 “Үсчний мэргэжлийн стандарт” боловсруулах,
- 2015 онд MNS 2015:6541 “Мэргэжлийн боловсрол, сургалт, ерөнхий шаардлага стандартыг боловсруулах ажлын хэсэгт,
- 2020 онд үсчний мэргэжлийн “Ажил мэргэжлийн стандарт” боловсруулах ажлын хэсэгт тус тус ажилласан.

ҮР ДҮН: Мэргэжлийн боловсролын салбарын үйл ажиллагаанд одоо болтол хэрэгжиж байна.




САЙН ТУРШЛАГА 2: “ЧАДАМЖИД СУУРИЛСАН СУРГАЛТЫН ЖУРНАЛ”-ЫГ БОЛОВСРУУЛЖ СУРГАЛТАД НЭВТРҮҮЛСЭН.

Хөдөлмөрийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2013 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/35 тоот тушаалаар “Суралцагчийн мэдлэг, ур чадварыг үнэлэх дүгнэх журмыг боловсруулах ажлын хэсэг” байгуулагдаж Улаанбаатарын бүсийн арга зүйн төвтэй хамтран ажиллаж 4 ажил хэрэгжүүлсний нэг нь “Чадамжид суурилсан сургалтын журнал” байсан.

ҮР ДҮН: Үнэлгээний бичиг баримтуудын бүтцийг судалж харьцуулан анализ, синтезийн аргаар судалгаа хийж загварын анхны хувилбарыг боловсруулсан. Энэ бүтээл нь журналд тавигдах ерөнхий шаардлага, ЧСС-ын бүрэлдэхүүн хэсэг, үндсэн чадмалын нэгж, элемент, үнэлгээний болон гүйцэтгэлийн шалгуур гэх мэт сургалтын бүх талын үйл явцыг багтаан оруулснаараа давуу талтай болж чадсан. Энэхүү журналыг хэрхэн ашиглах талаар зөвлөмжийг youtube сувагт байршуулж олон нийтэд нээлттэй хэлбэрээр түгээн дэлгэрүүлсэн.

<https://www.youtube.com/watch?v=LlHiz3isQs>

2015 оноос одоог хүртэл үндэсний хэмжээнд тасралтгүй ашиглаж байна.



САЙН ТУРШЛАГА 3: ҮСЧНИЙ НОМ СУРАХ БИЧИГ ГАРЫН АВЛАГА БОЛОВСРУУЛСАН.

“Үс заслын технологи”, “Үсчин мэргэжлийн онол, техник” -3 боть ном зохиосон нь үсчний мэргэжлээр монгол улсад анх удаа гарсан цуврал бүтээл болсон байна. Энэхүү бүтээл нь үсчин болон үсчний мэргэжлээр төгсөгч, суралцагчдад зориулан онолын суурь мэдлэгийн шинжлэх ухааны үндэслэлтэй бичсэнээрээ өмнөх бүтээлээс давуу болж чадсан байна.



САЙН ТУРШЛАГА №7

ПУНЦАГИЙН МӨНХЖАРГАЛ



МБС-ийн байгууллагад 24 жил гоо заслын багшаар ажиллаж байна. Монгол улсын “МАСТЕР ГОО ЗАСАЛЧ”, “АЛТАН ГАДАС” одонт, “ТЭРГҮҮЛЭХ” багш.

МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛСЭН БАЙДАЛ:


- Япон улсын Токиогийн “Nichibi” мэргэжлийн сургуультай хамтын ажиллагааны гэрээ хийсэн.

- БНХАУ-ын Хөх хотод гоо заслын технологийн мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан.
- Япон улсын Токиогийн мэргэжлийн сургуульд мэргэжил дээшлүүлсэн.

САЙН ТУРШЛАГА 1: МЭРГЭЖЛИЙН СТАНДАРТ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫГ ХЭСЭГТ АЖИЛЛАСАН.

БШУЯ-ны мэргэжилтнүүдтэй хамтран мэргэжлийн стандарт боловсруулсан.


ҮР ДҮН: Ном болж хэвлэгдэн мэргэжлийн сургуулиуд сургалтад мөрдөж байна.



САЙН ТУРШЛАГА 2: МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТАД ЗОРИУЛСАН НОМ, ГАРЫН АВЛАГА, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛ БИЧИЖ, БОЛОВСРУУЛАН "ГОО ЗАСАЛЧ" МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТАД НЭВТРҮҮЛСЭН.

ҮР ДҮН:

- “Гоо засалч”-ийн мэргэжил эзэмшүүлж байгаа сургуулиудад зориулсан сурах бичиг 5-ыг бичиж боловсруулсан ба улсын хэмжээнд гоо заалчийн сургалтад өргөн ашиглаж байна.
- Гарын авлага 60 гаруй төрлийг боловсруулсан.
- Эрдэм шинжилгээний илтгэл 50 гаруй төрлийг бичиж боловсруулсан.



САЙН ТУРШЛАГА №8

ГОНЧИГДОРЖИЙН ЖАРГАЛСАЙХАН



Боловсролын байгууллагад 23 жил, мэргэжлийн боловсролын салбарт 22 жил ажиллаж байна. “ОЁДЛЫН МАСТЕР БАГШ”, оёдлын салбарын мэргэжлийн зөвлөлийн гишүүн, “ТЭРГҮҮЛЭХ” багш.

САЙН ТУРШЛАГА 1: ЧАДАМЖИЙН ҮНЭЛГЭЭНИЙ САН БҮРДҮҮЛСЭН.


Стандартад нийцсэн үнэлгээний төлөвлөгөө боловсруулж, үнэлгээний санг төгсөлтийн, чадамжийн нэгжийн, чадамжийн элементийн гэсэн ерөнхий ангиллаар боловсруулан, баяжуулан хэрэглэж байна.

ҮР ДҮН: Оёдлын мэргэжлийн үнэлгээний үйл явц жигдэрсэн. Оёх ур чадварыг эцсийн бүтээгдэхүүний гүйцэтгэлээр үнэлдэг бөгөөд ажил бүрт тохирсон үнэлгээний шалгуур боловсруулсан нь суралцагчид ямар ажилбар дээр гүйцэтгэл дутуу хийж байгаадаа хяналт тавих боломж нээгдэж, үнэлгээ нээлттэй ил тод болсон.

Монгол улсын хэмжээнд Оёмол бүтээгдэхүүний стандартад нийцсэн үнэлгээний нэгдсэн сан байхгүй бөгөөд мэргэжлийн II, III, IV түвшинд үнэлгээний сорил боловсруулан, хянуулах ажлыг ШУТИС-тай хамтран хийж байна.

САЙН ТУРШЛАГА 2: ЧАДАМЖИЙН НЭГЖ БҮРЭЭР ЦАХИМ ХЭРЭГЛЭГДЭХҮҮНИЙ САН ҮҮСГЭЖ, ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛСЭН.

ҮР ДҮН: Суралцагчдын бие дааж суралцах чадварыг нэмэгдүүлэх, өөрийн технологи арга барилаа түгээн дэлгэрүүлэх зорилгоор my youtube сувгийг ашиглан видео хэлбэрээр хичээлүүдийг бэлтгэн сургалтанд ашиглаж байна.



САЙН ТУРШЛАГА 3: АЖИЛ ОЛГОГЧИДТОЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ, ОЁДЛЫН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БҮЙ АЖ АХУЙ НЭГЖҮҮДЭД МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨН ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЖ, ЦАХИМ БОЛОН ТАНХИМААР ОНОЛЫН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛСАН.

ҮР ДҮН: Өөрийгөө үнэлэх, мэдлэгээ нэмэгдүүлэх, мэргэжлийн зэргээ ахиулах, байгууллагад стандартад нэвтрүүлэх зэрэг үйл ажиллагааг жигдрүүлсэн.

“Өнөр баян хайрхан” ХХК-ны оёдлын бичиг баримт боловсруулалтад зөвлөн тусласнаар оёдлын салбарт анхны чанарын менежментийн тогтолцоог хэрэгжүүлэгч байгууллага болсон.



САЙН ТУРШЛАГА №9

ПЭРЭНЛЭЙН ЧУЛУУНБАТ



Боловсролын байгууллагад 26 жил ажиллаж байгаа, мехатроникийн холбооны гишүүн, Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн тэнхимийн эрхлэгч, багш, “ЗӨВЛӨХ” багш.

САЙН ТУРШЛАГА 1: СУРАЛЦАГЧДЫН ДУНД МЭРГЭЖЛЭЭРЭЭ ДАДЛАГАЖИХ, УР ЧАДВАР ЭЗЭМШИХ ОЛОН АЖЛУУДЫГ ТОГТМОЛ ЗОХИОН БАЙГУУЛДАГ.

ҮР ДҮН:

- “Монгол ур чадвар” тэмцээнд “Цахилгаанчин, гагнуурчин” мэргэжлээр суралцагчдаа бэлтгэж оролцуулдаг.
- “Автомат робот” уралдааныг уламжлал болгон улсын хэмжээнд зохион байгуулдаг.
- Суралцагчдын ур чадварын уралдааныг зохион байгуулдаг.

САЙН ТУРШЛАГА 2: СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮЙЛДВЭРЛЭЛД НЭВТРҮҮЛЖ, АЖИЛ ОЛГОГЧИДТОЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ БАЙНА.

ҮР ДҮН:

- БНСУ-д болсон олон улсын “Innovation 4 Blue skies” уралдаанд “Эко цахилгаан үүсгүүр” бүтээлээр оролцож, шилдэг инновацид шалгарсан.
- МБСБ-ын багш нарын дунд зохион байгуулдаг шилдэг инновацийн уралдаанд “LED телевизор, электрон цаг” бүтээлээр тэргүүн байр эзэлсэн.
- “Smart box” ХХК-д зөвлөх инженерээр ажилладаг.
- “TESO” ХХК, “Оюутолгой” ХК, “Таван толгой” ХК-ийн инженер, техникийн ажилтнуудад, МБСБ-ын мэргэжлийн багш нарт чадавхжуулах сургалт зохион



ЭМХЭТГЭН БОЛОВСРУУЛСАН:

Д.НАРАНТУЯА -Багшийн хөгжил, инновац хариуцсан арга зүйч

ЗӨВЛӨЖ, ХЯНАСАН:

Б.МЯДАГБАДАМ -Сургалтын менежер



